



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 18 өдөр

Дугаар A/10

Мандалговь

Ахмад настны харъяаллын тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, сумын Засаг даргын үйл ажилгааны хөтөлбөрийн 2.4.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Тус сумаас шилжсэн, нас барсан ахмад настнуудыг тухайн байгууллага, ААНэгжийн харъяаллаас хасаж, сумандаа амьдарч байгаа харъяалах байгууллаагүй нэр бүхий 8 ахмад, харъяалалгүй 27 ахмад настанг аж ахуй нэгж, байгууллагад шинээр харъяалуулан нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Хуулийн дагуу “Монголын цагаан сар”, “Ахмадын баяр”-аар хүлээн авч хүндэтгэл үзүүлж, мэдээгээ 3 хоногийн дотор сумын Ахмадын хороонд ирүүлж байхыг Мандалговь хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, ААНэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (О.Уранзаяа), сумын ахмадын хорооны дарга (Ж.Намчиндулам) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

